



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 12 сарын 23 өдөр

Дугаар А/657

Хэрлэн сум

Эвентийн маркетинг, сурталчилгаа, шторкийн зардалд хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсэг, 14.2.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хоёрдугаар хуралдааны 2020 оны 06 дугаар (Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай) тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Нээлттэй Хэнтий аймаг" хөтөлбөрийн хүрээнд орон нутгийн тэргүүлэх чиглэл болох аялал жуулчлалын арга хэмжээгээр дамжуулан орон нутгаа сурталчлах, иргэн, аж ахуй нэгж, жижиг дунд бизнес эрхлэгчдийг дэмжих, орлогыг нэмэгдүүлэх зорилгоор "Талын түмэн адуу" арга хэмжээг зохион байгуулахад шаардагдах эвентийн маркетинг, сурталчилгаа, шторкийн зардалд 3,500,000 (гурван сая таван зуун мянга) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Шаардагдах хөрөнгийг хавсралтаар баталсугай.

3. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг Засаг даргын үйл ажиллагааны "Нээлттэй Хэнтий аймаг хөтөлбөр"-ийн арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Н.Үнэнбат)-д гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Э.Мөнх-эрдэнэ)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Д.АЮУРБУНЬ



Аймгийн Засаг даргын 2024 оны
12 дугаар сарын 15-ний өдрийн
А/659 дугаар захирамжийн хавсралт

ЭВЕНТИЙН МАРКЕТИНГ,
СУРТАЛЧИЛГАА, ШТОРКИЙН ЗАРДЛЫН ТООЦОО

№	Нэр төрөл	Тоо хэмжээ	Нэгжийн төлбөр	Нийт /төг/
1	Дизайн, эх бэлтгэл			450.000
2	Шторк, видео	1ш	2.000.000	2.000.000
3	Төлбөртэй сурталчилгаа/фэйсбүүк, инстаграм бүүст/	3 удаа	350.000	1.050.000
Нийт дүн				3.500.000